



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 04 өдөр

Дугаар А/355

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын хамтарсан 2022 оны 95/260 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2023 оны “Автомашины тоо, төрөл тогтоох тухай” А/403 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд орон нутгийн өмчит болон оролцоотой хуулийн этгээдийн илүүдэлтэй автомашиныг хууль тогтоомжид заасны дагуу татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Х.Цэнд-Аюуш (аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга)

Гишүүд:

Э.Улам-Өсөх (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шилжилгээ үнэлгээний хэлтсийн Төрийн бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан ахлах мэргэжилтэн)

Х.Буянтогтох (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, орон нутгийн өмч, жижиг, дунд үйлдвэрлэл, хоршооны бодлого үйл ажиллагааг зохион байгуулах мэргэжилтэн)

Б.Батнасан (аймгийн Орон нутгийн өмчийн газрын Нярав, жолооч)

Нарийн бичгийн дарга:

А.Энхжаргал (аймгийн Орон нутгийн өмчийн газрын Өмчийн ашиглалт, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн)

2. Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйлчилгээний болон тусгай хэрэгцээний автомашиныг хууль тогтоомжийн хүрээнд татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж, дүнг 2024 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Х.Цэнд-Аюуш)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батбилгүүн)-д даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

6712011033 Захирамж 2024